

# THE JOURNALISM FOR DEVELOPMENT

2010-2019

“ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН  
СҮЛЖЭЭ” ТӨСӨЛ

Trainings



## ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

## СЭТГҮҮЛ ЗҮЙ

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” 2010 оны дөрөвдүгээр сарын 19-нд байгуулагдсанаасаа хойш сэтгүүлчдийн дунд мэргэжил дээшлүүлэх сургалтыг нийслэл хотод, мөн орон нутгийн сэтгүүлчдэд зориулсан сургалт, хөрөнгийн зах зээлтэй танилцах аяллыг хилийн чанадад тус тус зохион байгуулсан юм.



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН  
БАЙГУУЛЛАГЫН СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН  
“УУЛ УУРХАЙН МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ АРГА ЗҮЙ” СУРГАЛТ

2010

Mining  
Journal



2010.06.20

Өмнөговь аймаг, Даланзадгад

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь Уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж буй Өмнөговь аймгийн хэвлэл мэдээллийн бүх байгууллагын сэтгүүлчид оролцсон “УУЛ УУРХАЙН МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ АРГА ЗҮЙ” сургалтыг 2010 онд зохион байгууллаа.



Орон нутгийн сэтгүүлчдэд эдийн засаг, уул уурхайн салбарын тухай ойлголт өгсөн анхны мэргэжих сургалтын ажил болсон гэдгээрээ Монголын хэвлэлийн түүхэнд үлдэх үйл явдал юм.



Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр нийтлэл бичиж, нэвтрүүлэг бэлтгэдэг бидэнд сургах гэхээсээ илүү сэтгүүлч андуудтайгаа хуваалцах туршлага байсан юм. Орон нутгийн сэтгүүлчид үзэг нэгтнүүдийнхээ хөдөлмөрийг үнэлж, ийм практик сургалтын үнэ цэн зайлшгүй байгааг хэлж, цаашид үргэлжлүүлэх том урам өгсөн юм. ■

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН ХОЙД БҮСИЙН СУРГАЛТ

# 2015

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Хоргоогч:  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

2015.05.26-27

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар хот

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын баг Сэлэнгэ аймагт “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн ХОЙД БҮСИЙН СУРГАЛТЫГ амжилттай зохион байгууллаа.



Орон нутгийн иргэдэд уул уурхайн мөн чанарыг ойлгуулах, бодит мэдээллээр хангахын тулд орон нутгийн редакци, сэтгүүлчдийг мэргэжлийн арга зүйгээр дэмжих гэсэн бидний тэмүүллийг Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөр дэмжсэнээр 2015 оны тавдугаар сард төсөл эхэлсэн юм.

Уул уурхай, эдийн засгийн мэдээллийг мэргэжлийн түвшинд бэлтгэдэг сэтгүүлчдийг улам олон болгох зорилгоо тэлсээр 2015 онд “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” байгуулсан билээ.



Тус сургалтад Орхон, Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул аймгийн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 20 сэтгүүлч хамрагдав. ■



# 2015

## “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН БАРУУН БҮСИЙН СУРГАЛТ

2015.06.25

Баянхонгор аймаг,  
Шаргалжуутын гол. “Өгөөж  
Булган” жуулчны бааз

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Харилцагч:  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын баг Баянхонгор аймагт “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн БАРУУН БҮСИЙН СУРГАЛТЫГ амжилттай зохион байгууллаа.



Алс Баян-Өлгий, Ховдын цэнхэр хязгаар, өмнийн шаргал Говь-Алтай, өврийн сайхан Өвөрхангай, говь хангай хосолсон Баянхонгор 5 аймгаас 27 сэтгүүлч зорин иржээ.



Сургалтын цагт ОУИТБС-ын тайланг хэрхэн зөв “унших”, яаж ойлгомжтой мэдээлэх, Сэлэнгэ, Баянхонгор аймгийн тайланг энгийн болгож мэдээлсэн туршлага, Баруун бүсэд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн үйлдвэрлэлийн онцлог, өнөөгийн нөхцөл, зах зээлийн төлөв, дэд бүтцийн асуудал, уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлага, түүний өгөөж, нөхөн сэргээлт, улс, орон нутгийн төсөвт өгч буй татварын хэмжээ, иргэд ба компанийн ойлголцол, Баруун бүсийн алтны салбарын онцлог, технологи, хэрэглээний талаарх мэдээлэл, Бичил уурхай тойрсон асуудлууд зэрэг өргөн хүрээтэй сэдвээр ММЖ-ийн багийнхан илтгэсэн. ■



# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН НЭГДСЭН УУЛЗАЛТ

# 2015

2015.11.10

Улаанбаатар хот. Blue Sky Tower

Mining  
Journal



германы  
ХАЙТЫН АЖИЛЛАГАА  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Харгалуулагч:  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

Mongolian Mining Journal-ийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ сэтгүүлчдийг чадавхижуулах сургалтын хүрээг тэлж, “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслөөр өргөтгөснийхөө НЭГДСЭН УУЛЗАЛТЫГ зохион байгуулж буй нь энэ.



Сургалтад оролцсон нийт сэтгүүлчдийн дунд уралдаан зарлах, нийслэл хотноо нэгдсэн уулзалт хийх, гадаадын уул уурхайн сургуулиудын мэргэжлийн профессоруудыг урьж хичээл заалгах, танилцах аялал зохион байгуулах зэргээр уг төслөө далайцтай болгон өргөжүүлэх шаардлага гарсан юм.

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн Нэгдсэн уулзалтад Хойд, Өмнөд, Баруун бүсийн сэтгүүлчид идэвхтэй оролцсон юм. ■



# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН НЭГДСЭН СУРГАЛТ

# 2016

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Харилцагч  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

2016.04.02

Улаанбаатар хот. Хууль зүйн  
хүрээлэнгийн “Хуульчид” танхим

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга /ЭТИС/ хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийг хоёр дахь жилдээ үргэлжлүүлэн зохион байгууллаа.



Амжилттай хэрэгжсэн төслийг үргэлжлүүлэх, орон нутгийн сэтгүүлчдийн эргэх холбоо, ур чадварыг дахин шат ахиулах зорилгоор 2016 оны “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл ажлаа эрчтэйгээр эхэллээ. Энэ удаад ЭТИС хөтөлбөр Германы туршлагатай, нэр хүндтэй сэтгүүлчийг урьсан юм. 2016 оны сургалтад өмнөх сургалтад хамрагдсан орон нутгийн хэвлэлийнхнээс 35 сэтгүүлч шигшигдэн оролцов. ■



# БОРООГИЙН АЛТНЫ УУРХАЙТАЙ ТАНИЛЦСАН СЭТГҮҮЛЧДИЙН АЯЛАЛ




Байгаль орчны асуудал сургалтын үндсэн сэдэвт багтаж буй болохоор уурхайн үйл ажиллагаа дууссан нөхөн сэргээлтийн ажил явагдаж буй уурхайтай танилцах аяллыг сонгожээ. Орон нутгийн болоод төвийн сэтгүүлчид багтсан нийт 40 хүнтэй баг бүрэлдэхүүн Улаанбаатар хотоос 110 км-т орших Бороогийн алтны уурхайг зорив.

Энэ жилийн эхний сургалтад Герман улсаас доктор Дирк Асендорфф уригдан багшилсан. Тэрээр уул уурхай, байгаль орчны сэдвээр дагнан бичсэн туршлагатай сэтгүүлч.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Их Даширын хөндий дэх алтны үндсэн ордыг түшиглэн хэрэгжсэн төслийн талбай дээр очсон сэтгүүлчдийг “Бороо гоулд” компанийн Үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирал Т.Оргодол хүлээн авч, уурхайнхаа талаар танилцуулсан.

Гурван өдрийн сургалтын дараа GIZ-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захирал Др.Ханселманн, Дэд захирал О.Батболд, “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-ын захирал Б.Алигэрмаа, багш Асендорфф нар орон нутгийн сэтгүүлчдэд сертификат гардууллаа. ■



# 2016

## “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН **НЭГДСЭН СУРГАЛТ**

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Хархорум  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

2016.08.14-15

Өвөрхангай аймаг, Хархорин  
сум

Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар, олон улсын музейн өндөр стандарт, шийдэлтэй баригдсан Хархорум музейн хурлын танхимд орон нутгийн сэтгүүлчдийн ээлжит сургалт эхлэв.



Төслөөс хэрэгжүүлж байгаа сургалт бүр өөрийн онцлогтой, шинэ санаа сэдвээр баяжигдсан, өмнөх сургалтуудынхаа үр дүнд суурилсан байдгаараа орон нутгийн сэтгүүлчдийн анхаарлыг татдаг. Энэ удаагийн сургалт дан сэтгүүл зүйн сэдвүүдээр дагнасан нь онцлог байв.



Хархорин сумын төвөөс таван километрийн зайд, Орхон голыг хаяалан байрших жуулчны кэмпүүд хол, ойрын зочдын хөлд дарагджээ. Тэдний нэг “Хаан тайж” жуулчны баазад орон нутгийн сэтгүүлчид буудалласан юм. “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас хоёр дахь жилдээ зохион байгуулж буй “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн ээлжит сургалтад хамрагдахаар алс холоос зорин ирсэн хэвлэлийн багууд ээлж дараалан буусан нь энэ юм. ■





# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН НЭГДСЭН СУРГАЛТ

# 2016

2016.11.14-15

Улаанбаатар хот. Blue Sky Hotel

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Хэрэгжүүлэгч  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөрийн дэмжлэгтэй хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулсан төслийн хаалтын нэгдсэн уулзалт боллоо.



Өнгөрсөн хугацаанд төслийн хүрээнд өөр өөрийн онцлог, үе шаттай зургаан удаагийн цуврал сургалтыг 15 аймгийн 70 орчим сэтгүүлчийг хамруулан зохион байгуулжээ. Эдгээр сургалтад идэвхтэй оролцсон 35 сэтгүүлч төгсгөлийн сургалт семинарт хамрагдсан юм.



Төгсгөлийн семинарт ХБНГУ-ын Мюнхен мужийн харьяат, сэтгүүлч Бернд Освальд цахим сэтгүүл зүйн чиг хандлага, түүний зөв зохистой хэрэглээний талаарх туршлагаа хуваалцсан юм.



Эрдэс баялгийн салбарын талаарх сэтгүүлчдийн боловсрол, хандлага, мэдлэг, ёс зүйг төлөвшүүлснээр нийгэмд зөв ойлголт, хандлага төлөвшиж чадна. Тиймээс сэтгүүлчдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөрөө уул уурхайн салбарын мэдлэг ойлголтоор хязгаарлалгүйгээр сэтгүүл зүйн салбарын хөгжлийн чиг хандлага, өөрчлөлтийн талаарх мэдээллийг ч хүргэхийг эрмэлздэг. ■

# 2017

## “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН ТАНИЛЦАХ АЯЛАЛ

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Харамжуулагч  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

Өмнөговь аймаг.

Ханбогд **2017.06-28-29**

Цогтцэций **2017.06.30**

Даланзадгад **2017.07.1-2**

Монгол орны 21 аймгаас ирсэн сэтгүүлчид нийслэл хотын хөл хөдөлгөөн эхлэхээс урьтан өмнийн говийн уул уурхайн үйл ажиллагаатай танилцахаар аян замдаа гарлаа. “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл энэ жил хүрээгээ тэлж, 21 аймгийн сэтгүүлчид сургалтад хамрагдаж байгаа юм.

2017 оны сургалтад 21 аймгийн 39 сэтгүүлч хамрагдсанаар Монгол орны өнцөг булан бүрт хүрсэн сүлжээ бий болж байна.



Өмнөговь  
аймаг. Ханбогд-  
Цогтцэций-  
Даланзадгад.  
“Оюутолгой”-н  
ил уурхай



Өмнөговь аймаг.  
Ханбогд-Цогтцэций-  
Даланзадгад.  
“Энержи Ресурс”-  
ийн Ухаахудагийн  
нүүрсний уурхай



Өмнөговь аймаг.  
Ханбогд-Цогтцэций-  
Даланзадгад.  
“Эрдэнэс  
Тавантолгой”  
компанийн Баруун  
Цанхи, Зүүн  
Цанхийн нүүрсний  
уурхай



# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН ХААЛТЫН СУРГАЛТ

# 2017

2017.10.9-10

Улаанбаатар хот. “Туушин” зочид  
буудал “Сүлд” танхим

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Харилцагч:  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH



“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн 2017 оны хаалтын сургалт  
“Туушин зочид буудлын “Сүлд” танхимд эхэллээ.



“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийг 2015, 2016 онд амжилттай хэрэгжүүлж, 6 удаагийн цуврал сургалтыг Сэлэнгэ, Баянхонгор, Өвөрхангай аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулсан билээ. Сургалтад хоёр жилийн хугацаанд 16 аймгийн 80 сэтгүүлч хамрагджээ.



“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн хүрээнд “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ нь сургалтад хамрагдсан орон нутгийн сэтгүүлчдийн оролцоог илүү үр дүнтэй болгож, сургалтаар олгосон мэдлэгийг бататгахын тулд нийтлэл нэвтрүүлгийн уралдаан зарлаж, дүгнэдэг уламжлалтай.

# “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН 21 АЙМГИЙН **НЭГДСЭН СУРГАЛТ**

# 2018

2018.05.28-29

Төв аймаг, Монгол-Кувейтын  
Байгаль хамгаалах төв

Зохион байгуулагч:




Дэмжигч байгууллага:

Төслийн хүрээнд энэ онд нийт гурван удаагийн цуврал сургалт хийгдэх ба эхний сургалт Төв аймаг дахь Монгол Кувейтын байгаль хамгаалах төвд зохиогдлоо.



The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ төслийг 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд нийт 8 удаагийн цуврал сургалтад 21 аймгийн давхардсан тоогоор 100 гаруй сэтгүүлч хамрагдав.



Энэхүү төсөл 2018 онд “Оюутолгой” ХХК болон GIZ-ийн ЭТИС хөтөлбөр, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхмийн дэмжлэгтэй хэрэгжиж байна. Сургалтын эхний өдөр уул уурхай, эдийн засгийн сэдэвт чиглэсэн бол хоёр дахь өдөр сэтгүүл зүйн салбарын чиг хандлагын асуудалд төвлөрсөн юм.



# 2018

## “ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛЧДИЙН СҮЛЖЭЭ” ТӨСЛИЙН 21 АЙМГИЙН ТАНИЛЦАХ АЯЛАЛ

Зохион байгуулагч:



Дэмжигч байгууллага:



2018.10.13-14

Өмнөговь аймаг, Цогтцэций,  
Ханбогд сум, Оюутолгойн уурхай

Сэтгүүлчид “Оюутолгой”-н Оюут ил уурхай, Баяжуулах үйлдвэр, Эрсдэлийг үзүүлэх төв болон гүний уурхайн бүтээн байгуулалттай бодитоор танилцав.



The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ орон нутгийн сэтгүүлчдийн уул уурхай, эдийн засгийн мэдлэг, ойлголтыг тэлэх үе шаттай сургалтуудын 2018 оны ээлжит сургалтыг “Оюутолгой” ХХК болон МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхим, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж байгаа бөгөөд 21 аймгийн нийт 35 сэтгүүлчид хамрагдаж байна.



Сэтгүүлчдийн хувьд энэ удаагийн аяллаас хамгийн сонирхолтой хэсэг нь Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт байлаа.

# СЭТГҮҮЛЧДИЙГ УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭШҮҮЛЭХ МЕНТОРШИП ХӨТӨЛБӨР ЭХЭЛЖ БАЙНА

# 2018

Mining  
Journal



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Хоргоолууч  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

## 2018.04.10

Улаанбаатар хот. Германы Олон  
улсын хамтын ажиллагааны  
нийгэмлэг (GIZ)-ийн оффис

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй”  
ТББ-аас сэтгүүлчдийг чадавхжуулах 2018 оны ээлжит  
**ШИНЭ ХӨТӨЛБӨР** эхэлж байна.



(GIZ)-ийн ЭТИС  
хөтөлбөрийн захирал  
Karin Reinprecht



Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөр нь “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөлд хамтран ажиллахын зэрэгцээ 2016-2017 онд эдийн засаг, бизнесийн чиглэлээр мэргэшиж буй төвийн сэтгүүлчдэд зориулан онол, дадлагын сургалтын төслийг Австралийн Квийнсландын их сургуультай хамтран хэрэгжүүлсэн билээ.

GIZ-ийн ЭТИС хөтөлбөр, Хөгжлийн төлөө сэтгүүл зүй ТББ хамтран энэхүү хоёр төслийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулан өргөжүүлж, 2018 онд төвийн сэтгүүлчид орон нутгийн сэтгүүлчдэд туршлага, ур чадвараа эзэмшүүлэх Менторшип хөтөлбөрийг зохион байгуулан ажиллаж байна.



Хөтөлбөрийн хүрээнд  
6 сарын хугацаанд 3  
удаа суралцах, туршлага  
солилцох арга хэмжээ  
зохион явууллаа. ■

Менторшип програм нь төвийн сэтгүүлчид орон нутгийн сэтгүүлчдэд ажлын бодит туршлага өгч, халамжлан сургах байдлаар медиа салбарын орчин цагийн чиг хандлагатай нийцэн ажиллахыг практикаар заах зорилготой.

Менторшип хөтөлбөрт дээрх хоёр төсөлд хамрагдсан сэтгүүлчдээс нийт 16 сэтгүүлч сонгогдсон. Дагалдан суралцах ментий буюу 8 сэтгүүлчийг “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөлд хамрагдсан GIZ-ийн ЭТИС хөтөлбөр хэрэгжүүлэгч Баянхонгор, Сэлэнгэ, Увс болон Өмнөговь, Дорнод аймгаас нийт 8 сэтгүүлч сонгогдон суралцаж байна.